

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	3
1.2. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ, НӨӨЦ	5
1.3. УУРХАЙН КАЛЕНДАРЬ ТӨЛӨВЛӨЛТ	9
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ СУУРЬ НӨХЦӨЛ	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	15
3.1. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	15
3.2. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	15
3.3. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛЫН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	16
3.4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	16
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ	18
4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
4.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ	27
4.4. ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	28
4.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
4.6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
4.7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
4.8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	35
4.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	38
4.10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
4.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	42
4.12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	43

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-016896 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол.....	3
Хүснэгт 2. MV-022106 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол.....	3
Хүснэгт 3. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт /MV-016896/	6
Хүснэгт 4. Нөөцийн тооцооны хүснэгт /MV-022106/	6
Хүснэгт 5. Нөөцийн тооцооны хүснэгт /MV-022106/	7
Хүснэгт 6. Олборлосон нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт	7
Хүснэгт 7. Үлдэгдэл нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт	8
Хүснэгт 8. Ил уурхайн ажлын горим.....	9
Хүснэгт 9. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	10
Хүснэгт 10. Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	15
Хүснэгт 1. 2026 онд хэрэгжүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө зардал	19
Хүснэгт 1. 2026 онд хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	26
Хүснэгт 1. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	27
Хүснэгт 11. Мөчрийн тайрдыг тарих норм	29
Хүснэгт 12. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих ажлын зардлын тооцоо	29
Хүснэгт 13. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	31
Хүснэгт 1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	32
Хүснэгт 1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	35
Хүснэгт 1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	38
Хүснэгт 1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний зардал	41
Хүснэгт 1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	42
Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	43

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг.....	4
Зураг 2. Төслийн талбайн агаар сансрын зураг.....	4
Зураг 3. Төслийн талбайн фото зураг №1	5
Зураг 4. Төслийн талбайн фото зураг №2.....	5
Зураг 5. Саваа мөчрөөс тайраадас бэлтгэх арга	28
Зураг 6. Бургасны суулгацыг байрлуулах бүдүүвч зураг	29
Зураг 7. Төслийн талбай ойр орчим айл өрхүүд	30
Зураг 8. Галын аюулгүй арга хэмжээний зураг	34
Зураг 9. Аюултай хог хаягдлын цэг байршлын ерөнхий схем	37
Зураг 10. Мониторингийн цэгийн байршил.....	40

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Хамтын эх булаг" ХХК-нь Туулын зүүн дэнжийн алтны шороон ордод MV-022106, MV-016896 тоот ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг эзэмшдэг.

2011-2013 онуудад MV-016896 тоот талбайд ашиглалтын үеийн хайгуулын ажлыг Туулын зүүн дэнжийн алтны шороон ордын С2-8 блокийн баруун хэсэгт гүйцэтгэж нөөцийг бодитой В зэрэглэлээр шлихээр 122.956 кг, химийн цэврээр 112.321 кг-аар, тодорхой нөхцөлд үр ашигтай боломжтой Стнүа зэрэглэлээр шлихээр 1.761 кг, химийн цэврээр 1.608 кг-аар, боломжтой С зэрэглэлээр шлихээр 3.041 кг, химийн цэврээр 2.778 кг.

2015-2020 онд MV-022106 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэж нөөцийг бодитой В зэрэглэлээр шлихээр 116.13 кг, химийн цэврээр 98.81 кг-аар, боломжтой С зэрэглэлээр шлихээр 40.95 кг, химийн цэврээр 34.85 кг-аар тус тус тогтоожээ.

MV-016896 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцөд 2014 онд "Ляпислазурь эрдэнэ" ХХК-н уг ордын ТЭЗҮ-ийг 3 жил ашиглахаар төлөвлөсөн бөгөөд техник технологийн боломж болон эдийн засгийн байдлаас хамааран хүчин чадалдаа хүрч ажиллаагүй өдийг хүрсэн тул "Кеестон Ресурс" ХХК MV- 016896 тоот талбайн үлдэгдэл нөөцийг "Хамтын эх булаг" ХХК-ний өөрийн эзэмшлийн зэргэлдээ байрлах MV-022106 тоот талбайн нөөцтэй хамт ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар батлуулсан байна.

1.1. Төслийн байршил

Туулын зүүн дэнж нэртэй алтны шороон орд нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 240 км, Эрдэнэт хотоос 130 км, Булган аймгийн төвөөс 110 км, Өгөөмөр тосгоноос 4 км тус тус байрладаг.

Дээрх тусгай зөвшөөрлийн талбай нь М-48-137 дугаар планшетиин хавтгайд байрладаг.


Хүснэгт 1. MV-016896 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

Цэг	Зүүн уртраг			Хойд өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	104°	23'	50.4"	48°	19'	14.56"
2	104°	23'	50.33"	48°	18'	55.9"
3	104°	23'	32.93"	48°	19'	1.82"
4	104°	23'	32.93"	48°	18'	41.81"
5	104°	23'	21.93"	48°	18'	41.81"
6	104°	23'	21.94"	48°	19'	6.81"
7	104°	23'	30.94"	48°	19'	6.81"
8	104°	23'	37.94"	48°	19'	6.81"
9	104°	23'	46.94"	48°	19'	15.8"


Хүснэгт 2. MV-022106 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	104° 23' 30.94"	48° 20' 1.82"
2	104° 22' 42.4"	48° 20' 1.82"
3	104° 22' 42.4"	48° 19' 22"
4	104° 22' 53.94"	48° 19' 22"
5	104° 22' 53.94"	48° 18' 30.81"


Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
6	104° 23' 21.93"	48° 18' 30.81"
7	104° 23' 21.94"	48° 19' 6.81"
8	104° 23' 30.94"	48° 19' 6.82"



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



Зураг 2. Төслийн талбайн агаар сансрын зураг



Зураг 3. Төслийн талбайн фото зураг №1



Зураг 4. Төслийн талбайн фото зураг №2

1.2. Төслийн хүчин чадал, ажиллах горим, нөөц

Ордын нөөц: Ордын хайгуулын ажлын торын нягтралыг 60.0 м, 140-150х20-40 ийн тороор хангаж нөөцийн бодит В зэрэглэлд хангах боломж бүрдүүлсэн бөгөөд тус ордын тогтоц, хэлбэр ашигт болон хучаас давхаргуудын зузаан, алтны тархалтын ерөнхий зүй тогтол зэргийг одоо тухайн орд дээр явагдаж байгаа ашиглалтын ажлын үзүүлэлттэй уялдуулан тооцсон байна.

Ашиглалтын хайгуулын ажлыг Туул голын зүүн гар талын дэнж дээр байрлах С₂-8 блокийн баруун хойт, баруун хэсэгт гүйцэтгэсэн байна. Хайгуулын ажлын явцад цохилтот өрмийн нийт хайгуулын 7 шугамаар 56 цооног буюу 1938.9 т/м өрөмдөж, шижирмэг алтны нөөцийг бодитой В зэрэглэлээр нөөцийн ангилалд

хамрагдах 112.321 кг, боломжит С зэрэглэлээр 4.386 кг нийт 116.707 кг алт химийн цэврээр тооцсон байна.

Хүснэгт 3. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт /MV-016896/

Блокийн дугаар	ХШ дугаар	Блокийн	Зузаан, м		Дундаж	Эзлэхүүн, мян.м ³		Нөөц	
		талбай, м ²	Хөрс	Элс	агуулга, г/м ³	Хөрс	Элс	Шлих	Х.Цэвэр
Давхарга-2 /В зэрэглэлийн нөөц/									
1 ₂ -В ¹	881.5-882A	2772.4	46.3	0.9	1.242	128.4	2.495	3.099	2.83
1 ₂ -В	881.5-882a	5322.91	36.95	1.8	1.114	196.68	9.581	10.673	9.75
2 ₂ -В	882a-882	7719.45	34.19	1.57	1.015	263.9	12.120	12.301	11.24
3-В	882-882.5	13759.71	32.9	1.27	1.092	452.7	17.475	19.083	17.43
4-В	882.5-883	33593.1	28.18	1.27	0.891	946.7	42.663	38.013	34.72
5-В	883-884	23901.8	22.6	1.26	0.476	540.2	30.116	14.335	13.10
6-В	884-885	15952.69	25.49	1.24	0.364	406.6	19.781	7.200	6.58
7-В	886к-885	24144.56	25.86	1.29	0.586	624.4	31.146	18.252	16.67
В		127166.62	27.99	1.30	0.74	3559.51	165.38	122.96	112.32
Давхарга-2 /Стнүа зэрэглэлийн нөөц/									
2 ₂ -С	882A-881.5	2212.84	46.00	0.60	1.28	101.79	1.33	1.70	1.55
3-С	882-882.5	3079.29	43.6	0.2	0.106	134.3	0.616	0.065	0.06
С		5292.13	44.60	0.37	0.91	236.05	1.94	1.76	1.61
Давхарга-1 /С зэрэглэлийн нөөц/									
4-С	884.00	1768.52	11.20	0.80	0.134	19.81	1.415	0.189	0.17
5-С	883-884	5903.03	11	0.6	0.15	64.9	3.542	0.531	0.49
6-С	884-885	12820.23	13.50	0.60	0.30	173.07	7.692	2.321	2.12
С		20491.78	12.58	0.62	0.24	257.81	12.65	3.042	2.78
Бүгд дээд доод давхарга									
Нийт В		127166.62	27.99	1.30	0.74	3559.51	165.38	122.96	112.32
Нийт С		25783.91	19.15	0.57	0.33	493.86	14.59	4.80	4.39
Бүгд В+С		152950.53	26.50	1.18	0.71	4053.37	179.97	127.760	116.708

2015-2020 онд MV-022106 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэж нөөцийг бодитой В зэрэглэлээр шлихээр 116.13 кг, химийн цэврээр 98.81 кг-аар, боломжтой С зэрэглэлээр шлихээр 40.95 кг, химийн цэврээр 34.85 кг нөөц бүртгэсэн бөгөөд ашиглалтын үйл ажиллагаа явагдаагүй болно.

Хүснэгт 4. Нөөцийн тооцооны хүснэгт /MV-022106/

Блокийн дугаар	ХШ дугаар	Блокийн	Зузаан, м		Дундаж	Эзлэхүүн, мян.м³		Нөөц	
		талбай, м²	Хөрс	Элс	агуулга, г/м³	Хөрс	Элс	Шлих	Х.Цэвэр
Давхарга-2 /В зэрэглэлийн нөөц/									
1 ₂ -В ¹	881.5-882A	2772.4	46.3	0.9	1.242	128.4	2.495	3.099	2.83
1 ₂ -В	881.5-882a	5322.91	36.95	1.8	1.114	196.68	9.581	10.673	9.75
2 ₂ -В	882a-882	7719.45	34.19	1.57	1.015	263.9	12.120	12.301	11.24
3-В	882-882.5	13759.71	32.9	1.27	1.092	452.7	17.475	19.083	17.43
4-В	882.5-883	33593.1	28.18	1.27	0.891	946.7	42.663	38.013	34.72
5-В	883-884	23901.8	22.6	1.26	0.476	540.2	30.116	14.335	13.10
6-В	884-885	15952.69	25.49	1.24	0.364	406.6	19.781	7.200	6.58
7-В	886к-885	24144.56	25.86	1.29	0.586	624.4	31.146	18.252	16.67
В		127166.62	27.99	1.30	0.74	3559.51	165.38	122.96	112.32
Давхарга-2 /Стнүа зэрэглэлийн нөөц/									
2 ₂ -С	882A-881.5	2212.84	46.00	0.60	1.28	101.79	1.33	1.70	1.55
3-С	882-882.5	3079.29	43.6	0.2	0.106	134.3	0.616	0.065	0.06
С		5292.13	44.60	0.37	0.91	236.05	1.94	1.76	1.61
Давхарга-1 /С зэрэглэлийн нөөц/									
4-С	884.00	1768.52	11.20	0.80	0.134	19.81	1.415	0.189	0.17
5-С	883-884	5903.03	11	0.6	0.15	64.9	3.542	0.531	0.49
6-С	884-885	12820.23	13.50	0.60	0.30	173.07	7.692	2.321	2.12
С		20491.78	12.58	0.62	0.24	257.81	12.65	3.042	2.78
Бүгд дээд доод давхарга									
Нийт В		127166.62	27.99	1.30	0.74	3559.51	165.38	122.96	112.32
Нийт С		25783.91	19.15	0.57	0.33	493.86	14.59	4.80	4.39
Бүгд В+С		152950.53	26.50	1.18	0.71	4053.37	179.97	127.760	116.708

2015-2020 онд MV-022106 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэж нөөцийг бодитой В зэрэглэлээр шлихээр 116.13 кг, химийн цэврээр 98.81 кг-аар, боломжтой С зэрэглэлээр шлихээр 40.95 кг, химийн цэврээр 34.85 кг нөөц бүртгэсэн бөгөөд ашиглалтын үйл ажиллагаа явагдаагүй болно.

Хүснэгт 5. Нөөцийн тооцооны хүснэгт /MV-022106/

Геологийн нөөц								
Блокийн дугаар, нөөцийн зэрэг	Дундаж зузаан /м/		Дундаж агуулга мг/м³	Блокийн талбай м²	Эзлэхүүн мян. м³		Алтны нөөц.кг	
	Хучаас	Элс			Хучаас	Элс	Шлих	Хими цэвэр
Дэнжийн хэсэг								
1В	68.09	1.49	792.97	11340.00	772.13	16.88	13.39	11.39
2В	69.94	1.62	757.73	42220.00	2952.87	68.40	51.83	44.10
3В	71.17	1.65	950.26	32530.00	2315.37	53.58	50.91	43.32
Нийт В:				86090.00	6040.37	138.86	116.13	98.81
4С	68.13	1.13	736.29	3568.00	243.10	4.04	2.97	2.53
Нийт С:				3568.00	243.10	4.04	2.97	2.53
Нийт В+С:	70.08	1.59	833.48	89658.00	6283.47	142.90	119.11	101.35
Өндөр дэнжийн хэсэг								
5С	79.88	1.24	1154.16	16270.00	1299.65	20.17	23.28	19.81
6С	79.93	1.13	1647.94	7866.00	628.76	8.91	14.69	12.50
Нийт С:				24136.00	1928.40	29.09	37.97	32.31
Нийт ордын хэмжээнд В:	70.16	1.61	836.31	86090.00	6040.37	138.86	116.13	98.81
Нийт ордын хэмжээнд С:	78.38	1.20	1236.02	27704.00	2171.50	33.13	40.95	34.85
Нийт ордын хэмжээнд В+С:	72.16	1.51	913.31	113794.00	8211.87	171.99	157.08	133.66

“Хамтын эх булаг” ХХК-нь 2014 оноос Туулын зүүн дэнжийн орд дээр ашиглалт явуулсан бөгөөд ашигласан нөөцийн хэмжээг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 6. Олборлосон нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Олборлосон нөөц						
Блокийн дугаар		Блокийн талбай, м²	Эзлэхүүн, мян.м³		Нөөц, кг	
			Хөрс	Элс	Шлих	Х.Цэвэр
MV-016896	Давхарга-2 /В зэрэглэлийн нөөц/					
	1 ₂ -В¹	2,772.40	128.36	2.50	3.10	2.83
	1 ₂ -В	5,235.519	193.47	9.58	10.67	9.75
	2 ₂ -В	7,719.5	264.01	12.12	12.30	11.24
	3-В	9,625.9	316.69	12.22	6.40	5.85
	4-В	13,971.1	393.98	17.74	9.40	8.58
	5-В	5,401.8	122.08	6.81	9.75	8.91
	6-В	-	-	-	-	-
	7-В	-	-	-	-	-
	В	44,726.1	1,418.60	60.97	37.86	34.58
	Давхрага-1 /Стнүа зэрэглэлийн нөөц/					
	2 ₂ -С	2,212.8	101.79	1.33	1.70	1.55
	3-С	3,079.3	134.26	0.62	0.06	0.06
	С	5,292.1	236.05	87.46	1.76	1.61
	Давхрага-1 /С зэрэглэлийн нөөц/					
	4-С	-	-	-	-	-
	5-С	-	-	-	-	-
	6-С	-	-	-	-	-
	С	-	-	-	-	-
	Бүгд дээд доод давхарга					
	Нийт В	2,212.8	61.96	60.97	45.33	41.41
	Нийт С	3,079.3	58.98	87.46	28.79	26.30
	Бүгд В+С	5,292.1	120.94	148.43	74.12	67.71
MV-022106	Дэнжийн хэсэг					
	1В	-	-	-	-	-
	2В	-	-	-	-	-
	3В	-	-	-	-	-
	В	-	-	-	-	-
	4С	-	-	-	-	-
	С	-	-	-	-	-
	В+С:	-	-	-	-	-
	Өндөр дэнжийн хэсэг					

Олборлосон нөөц						
Блокийн дугаар	Блокийн талбай, м²	Эзлэхүүн, мян.м³		Нөөц, кг		
		Хөрс	Элс	Шлих	Х.Цэвэр	
5С	-	-	-	-	-	
6С	-	-	-	-	-	
С	-	-	-	-	-	
Нийт В	-	-	-	-	-	
Нийт С	-	-	-	-	-	
Бүгд В+С	-	-	-	-	-	
Нийт В	2,212.8	61.96	60.97	45.33	41.41	
Нийт С	3,079.3	58.98	87.46	28.79	26.30	
Бүгд В+С	5,292.1	120.94	148.43	74.12	67.71	

2014 оноос Туулын зүүн дэнж алтны шороон ордоос бодитой В зэргийн 22-В, 3-В, 4-В, 5-В, 22-С, 3-С блокуудаас химийн цэврээр 67.71кг алтны нөөц олборлож ашигласан байна. 2025 оны 01-р сарын 01-ний байдлаар Туулын зүүн дэнж алтны шороон ордын үлдэгдэл нөөцийн тооцоог дараах хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 7. Үлдэгдэл нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Үлдэгдэл нөөц						
Блокийн дугаар		Блокийн талбай, м²	Эзлэхүүн, мян.м³		Шлих	Х.Цэвэр
			Хөрс	Элс		
MV-016896	Давхарга-2 /В зэрэглэлийн нөөц/					
	1 ₂ -В¹	-	-	-	-	-
	1 ₂ -В	-	-	-	-	-
	2 ₂ -В	-	-	-	-	-
	3-В	4,133.9	316.7	5.25	12.68	11.58
	4-В	19,622.0	553.34	24.92	28.62	26.14
	5-В	18,500.0	418.10	23.31	4.58	4.19
	6-В	15,952.7	406.79	19.78	7.20	6.58
	7-В	24,144.6	625.34	31.15	18.25	16.67
	В	82,353.2	2,320.27	104.41	71.33	65.16
	Давхарга-1 /Стнүа зэрэглэлийн нөөц/					
	2 ₂ -С	-	-	-	0.00	0.00
	3-С	-	-	-	0.00	0.00
	С	-	-	-	0.00	0.00
	Давхарга-1 /С зэрэглэлийн нөөц/					
	4-С	1,768.5	19.74	1.41	0.19	0.17
	5-С	5,903.0	62.57	3.54	0.53	0.49
	6-С	12,820.2	172.43	7.69	2.32	2.12
	С	20,491.8	254.74	12.64	3.04	2.78
	Бүгд дээд доод давхарга					
	Нийт В	82,353.16	2,320.27	104.41	71.33	65.16
	Нийт С	20,491.78	254.74	12.64	3.04	2.78
	Бүгд В+С	102,844.94	2,575.01	117.05	74.37	67.94
MV-022106	Дэнжийн хэсэг					
	1В	11,340.0	772.13	16.88	13.39	11.39
	2В	42,220.0	2,952.87	68.40	51.83	44.10
	3В	32,530.0	2,315.37	53.58	50.91	43.32
	В	86,090.0	6,040.37	138.86	116.13	98.81
	4С	3,568.0	243.10	4.04	2.98	2.53
	С	3,568.0	243.10	4.04	2.98	2.53
	В+С:	89,658.0	6,283.47	142.90	119.11	101.35
	Өндөр дэнжийн хэсэг					
	5С	16,270.0	1,299.65	20.17	23.28	19.81
	6С	7,866.0	628.76	8.91	14.69	12.50
	С	24,136.0	1,928.41	29.09	37.97	32.31
	Нийт В	168,443.2	8,360.64	243.27	187.46	163.97
	Нийт С	48,195.8	2,426.25	45.77	43.99	37.62
	Бүгд В+С	216,638.9	10,786.89	289.03	231.45	201.59

2025 оны байдлаар Туулын зүүн дэнж ордын бодитой В зэргийн үлдэгдэл нөөц химийн цэврээр 163.97 кг, боломжтой С зэргээр 34.62 кг, нийт химийн цэврээр 201.59 кг алтны нөөц үлдсэн байна. MV-016896, MV-22106 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд үлдсэн нөөцөд тулгуурлан, ордыг ил уурхайн аргаар ашиглах тодотгол техник-эдийн засгийн үндэслэлийн төлөвлөлт эдийн засгийн үнэлгээ хийлээ.

Уурхайн ажлын горим: Уурхай нь жил бүрийн 4-р сарын 10-аас бэлтгэл ажлыг эхлүүлж, 5-р сарын 10-аас 10-р сарын 20 хүртэл хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт 8. Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хөрс хуулах
Календарь хоног	хоног	214
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
Ээлжийн тоо	ээлж	2
Сард ажиллах хоног	хоног	30
Баяр ёслолын хоног	хоног	8
Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	6
Засвар үйлчилгээ хийх өдрүүд	хоног	8
Бэлтгэл ажлын хоног	хоног	5
Жилд ажиллах сар	сар	6
Жилд ажиллах хугацаа	хоног	187

Хөрс хуулалтад ажиллах цэвэр ажлын хоног 187 байна.

Хүчин чадал: Туулын зүүн дэнжийн алтны шороон ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголд жилд хуулах хөрс, олборлох элсний хэмжээг “Хамтын Эх Булаг” ХХК-ийн уурхайд ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал, төсөл захиалагчийн техникийн даалгаврын дагуу жилд 60.0 мян.м3 элс олборлон угаахаар төсөлд тусгалаа.

1.3. Уурхайн календарь төлөвлөлт

2024 оны 1-р сарын байдлаар Туулын зүүн дэнжийн алтны шороон ордын ашиглалт 5-В блок дээр явагдаж байсан байна. Уг тодотгол ТЭЗҮ-ийн эхний жилд 3-В, 4-В, 5-В, 6-В блокуудад дээр буюу уурхайн хойд хананд тултал ашиглаж, 2-р хэсэг буюу MV-022106 талбайгаас хөрс хуулалтын ажил эхлэхээр төлөвлөсөн бөгөөд ашиглалтын 2-р жилд 6-В, 7-В, 3-В блокийн үлдэгдэл нөөцийг олборлон 2-р хэсэгт уулын ажил явуулахаар төлөвлөсөн байна.

Уулын ажлыг явуулахдаа хөрсний зузаан ихтэй блокуудын хөрсийг 10-20м гидравлик экскаватораар суулгана. Ингэснээр ЭШ-10/60 алхагч экскаваторын утгалтын хамгийн их гүн уурхайн уурхайн уланд хүрэхээр болж байгаа бөгөөд 2-3 доголд зэрэг уулын ажил явагдах боломжтой болж байна.

ЭШ-10/60 алхагч экскаватор дотоод овоолготой ашиглалтын систем ашиглахыг эрмэлзэж байгаа нь хөрс хуулалтын явцад ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэх болон процессуудын хоорондын уялдаа холбоог уян хатан байлгах боломжийг бий болгож байгаа юм.

Ордын хөрсний зузаан 22.6-46.3 м, элсний зузаан 0.9-1.8 м байгаа тул уурхайн гүн дунджаар 30 м орчим байхаар байна. Уурхайн хажуугийн тогтворжилтыг хангахын тулд уурхайн хажуугийн өнцгийг 60 градусаас ихгүй налуутай байгуулна. Хөрс хуулалтын хэмжээн дээр хажуугаас нэмэгдэх хөрсний хэмжээг нэмж тооцоолсон. Уг тооцоог хийхдээ тухайн блокийн хөрс болон ашигт давхаргын нийлбэр гүн, уурхайн хажуугийн өнцгөөс нь хамааруулан ил уурхайн хажуугийн гурвалжин хэсгийн талбайг тодорхойлсон ба үүнийг тухайн блокийн

хоосон чулуулагтай харьцаж буй хүрээний уртаар үржүүлэх байдлаар блок тус бүр дээр тооцсон болно.

Хөрс хуулалт болон олборлолтын ажлын зохион байгуулалт болон уулын ажлын өрнөл дарааллыг ашиглалтын жил бүрээр дараах байдлаар харуулав.

Хүснэгт 9. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хөрс	Элс	Дундаж агуулга	Алт	
	мян.м ³	мян.м ³	г/м ³	Шлихээр кг	Химийн цэврээр кг
1-р жил	3196.0	60.0	0.69	29.82	27.24
2-р жил	3196.0	60.0	0.60	37.49	32.95
3-р жил	3196.0	60.0	0.78	46.08	39.21
4-р жил	3196.0	60.0	0.67	40.17	34.18
5-р жил	3196.0	38.673	1.04	38.32	32.61
Нийт	16096	278.67	0.7 3	20 4.7	177.86

Ашиглалтын 1-р жилд 3196.0 мян.м³ хөрс хуулж, 0.69 г/м³ дундаж агуулгатай 60.0 мян.м³ элс олборлож химийн цэврээр 38.05 кг алт олборлоно. 2-р жилд 3196.0 мян.м³ хөрс хуулж, 0.60 г/м³ дундаж агуулгатай 60.0 мян.м³ элс олборлож химийн цэврээр 31.64 кг алт, 3-р жилд 3196.0 мян.м³ хөрс хуулж, 0.60 г/м³ дундаж агуулгатай 60.0 мян.м³ элс олборлож химийн цэврээр 39.65 кг алт, 4-р жилд 3196.0 мян.м³ хөрс хуулж, 0.67 г/м³ дундаж агуулгатай 60.0 мян.м³ элс олборлож химийн цэврээр 34.21 кг алт, 5-р жилд 3196.0 мян.м³ хөрс хуулж, 1.04 г/м³ дундаж агуулгатай 60.0 мян.м³ элс олборлож химийн цэврээр 34.31 кг алт тус тус олборлохоор байна.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ СУУРЬ НӨХЦӨЛ

Уур амьсгал: Цаг агаарын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь $+2.8^{\circ}\text{C}$ байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1-р сар ба агаарын хэм нь -37°C , хамгийн дулаан сар нь 7-р сар ба агаарын хэм нь $+40^{\circ}\text{C}$ хүрдэг.

Агаарын температурын сарын дундаж нь нутгийн төв хэсгээр 12-17 градус, бусад нутгаар 17-22 градус дулаан буюу ихэнх уур амьсгалын дунджаас 1.0-2.0 градусаар дулаан байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар, нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө зарим газраар салхи түр зуур ширүүснэ. /Эх сурвалж: Булган аймгийн ус, цаг уур, орчин шинжилгээний алба/

Газрын гадаргуу: Судалгаа явуулсан нутагт дунд зэрэг өндөрлөгт болон нам уулсын, дов гүвээрхэг, тэгш гэсэн 4 төрлийн гадаргуу ялгасан байна. Дунд зэргийн гадаргуу нь районы төв хэсэг дэх Захцаг уулын өмнөд хэсгийн салбар уулс юм. Энэ уулс нь 1600 – 1816.2 м үнэмлэхүй өндөртэй ба харьцангуй өндөршилт нь 300 – 500 м байдаг байна. Төслийн талбай нь газрын гадаргын 0–5.6 градусын налуутай, далайн түвшнээс дээш 880.2–1041.4 м үнэмлэхүй өндөрт байрлана.

Агаарын чанар:Нарны цацрагийн жилийн явцаас хамааран сэрүүн бүсэд жилийн дөрвөн улирал ээлжилдэг. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг.

Булган аймгийн уур амьсгал нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс шинжтэй. Энд өвөл нь хүйтэн бөгөөд удаан үргэлжилнэ. Зун нь богино, халуун болдог. Хавар, намрын улиралд цаг агаар тогтворгүй эрс өөрчлөгдөж байдаг.

Ордын үйл ажиллагаанаас үүсэх үндсэн агаар бохирдуулагчид болох тоос,тоосонцрын ялгарлын орон зайн тархалтын хэмжээг эх үүсвэрийн тооцоолол,цаг уурын үзүүлэлтүүд болон газрын гадаргын өндөршлийн төлөвийг ашиглан тооцов.Ордын хувьд жилийн турш олборлолтын үйл ажиллагаа явагддаг тул тархалтын загварын үр дүнг Монгол улсын гадаад орчны агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага болох MNS 4585:2025 стандартын жилийн дундаж хүлцэх хэмжээтэй харьцуулав.Төслийн зүгээс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн хүрээг агаарт хамгийн ихээр ялгаруулж байгаа агаар бохирдуулагч бодисын агаарын чанарын стандартын хүлцэх хэмжээнээс давсан бохирдолтой хэсгээр зааглан тогтоов.Ордын олборлох үйл ажиллагаанаас ялгарах нийт тоосны MNS4585:2025 стандартын нийт тоосны жилийн дундаж хүлцэх агууламж болох 100мкг/м^3 давах хэсгийн дундаж агууламж 550мкг/м^3 буюу стандартаас 5.5 дахин(Зураг 17),PM10 тоосонцрын агууламж 250мкг/м^3 буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ 50мкг/м^3 агууламжаас 5.0 дахин (Зураг 18) давж, PM2.5 тоосны агууламж 30мкг/м^3 буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ 15мкг/м^3 хэмжээнээс 2.0 дахин их байна(Зураг 19).Уурхайн нөлөөллийн бүс буюу агаарын чанарт нөлөөлөх бүсийн талбайн хэмжээ 176 га талбайг хамарч байна(Зураг 20).

Гадаргын болон газрын доорх ус: Төслийн талбай нь гадаргын усны ангиллаар Туул голын сав газарт хамаарах бөгөөд хамгийн ойр орших гадаргын ус болох Туул гол нь төслийн талбайгаас зүүн зүгт ойролцоогоор 940 м зайд урсана.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд унд, ахуйн, технологийн, зам усалгаа болон ногоон байгууламжийн усны хэрэглээг төлөвлөсөн. Унд, ахуйн усны хэрэгцээг “Монполимет” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу гүний худгаас зөөврөөр хангахаар тусгасан. Харин технологийн хэрэгцээ болон зам усалгаанд шаардагдах усыг уурхайн малталтад шүүрэн орж ирэх усаар хангахаар төлөвлөсөн.

Хээрийн судалгааны ажлын хүрээнд 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр гүний худгаас усны дээж авч, “Грийн Лаб” ХХК-ийн усны шинжилгээний лабораторид хүргүүлэн химийн ерөнхий үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан. Шинжилгээний дүнгээр ундны усны бүх үзүүлэлтүүд MNS 0900:2018 “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдал” стандартын шаардлагыг бүрэн хангасан байна. Мөн хэмжигдсэн хүнд металл болон бусад химийн элементүүд стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд багтаж, усанд хүнд металлын бохирдол илрээгүй, унд ахуйн хэрэглээнд бүрэн тохиромжтой болох нь тогтоогдсон.

Түүнчлэн 2025 онд Монгол Улсын зөвлөх инженер, гидрогеологич Д. Хатанбаатарын гүйцэтгэсэн гидрогеологийн судалгаагаар уурхайн малталтад эхний жилд хоногт 481.55 м³ (цагт 20.0 м³) хэмжээний ус шүүрэн орох тооцоо гарсан бөгөөд уг тайланг энэ баримт бичгийн 5.3.2-р хэсэгт хавсаргасан болно.

Ус ашиглалтын тооцоог боловсруулж, холбогдох журмын дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт хүргүүлсний үндсэн дээр 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Е-2603-000123 дугаартай ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт боломжтой гэж гарсан.

Ургамлан нөмрөг: “Саут воли” ХХК-ийн судалгааны баг төслийн талбайд ургамалжилт болон ургамлын зүйлийн бүрдлийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр хээрийн судалгаа хийсэн. Судалгаа гүйцэтгэсэн газарт ургамал бүлгэмдлүүд бага зэрэг нөлөөлөлд өртсөн байсан. Судалгаа гүйцэтгэсэн аргачлалын дагуу ургамал бүлгэмдэл дараах өөрчлөлтөд орсон байна.

Зүйлийн бүрэлдэхүүн: Ургамал бүлгэмдэл флорын баялгаараа ядмаг болсон. Уулын хээрийн Хялгана- алаг өвст бүлгэмдэлд нэг наст Шарилж ургаснаар бүлгэмдлийн эдификатор ургамлын тоо эрс багасаж бүлгэмдэл антропогены сукцесст орсон. Мөн ойн нарс, гацуурын тоо цөөрч, сийрэг, давжаарсан байна.

Ургамалжлын арви: Арвийн үнэлгээний хувьд бүлгэмдлийн зонхилгоо зүйл *Stipasibirica*- сибирь Хялгана, *Pinus sylvestris*-ойн Нарс, *Larix sibirica*- сибирь Шинэс зэрэг **cop2** арвийн үнэлгээтэй, дэд зонхилгоо болон шургалагч зүйл ургамлууд нь **cop1- sp** арвитай байна. .

Ургамалжлын өсөлт, хөгжилт: Бүлгэмдлийн эдификатор ургамал *Stipasibirica*- сибирь Хялгана- 14,5 см. Тухайн бүлгэмдэл дэх хавар эртийн болон хаврын ургамлууд цэцэглэлтийн үедээ байсан. Үүнд: *Carex duriuscula*- ширэг Улалж, *Taraxacum officinale*- эмийн Бамбай, *Thlaspi cochleariforme*- халбаган Бираага, *Stellaria dichotoma*- ацан Ажигана, *Iris lactea*- цагаалин Цахилдаг, *Androsace incana*- буурал Далантовч, *Pulsatilla ambigua*- эдрээт Яргуй, *Pulsatilla flavescens*- шар Яргуй,

Potentilla acaulis- ишгүй Гичгэнэ, Potentilla bifurca- имт Гичгэнэ. Ургамалжлын аспект нь бор шаргал суурь дээр ногоон өнгийг үүсгэж байна. Бүлгэмдлийн хаврын дундаж ургац 5.5 цн.га.

Ан амьтан: Монгол орны амьтны аймгийн мужлалаар монгол төвдийн муж, ойт хээр ба хээрийн дэд муж, Монгол Дагуурын тойрогт хамаарна (Банников, 1954). Харин байгалийн бүсийн хувьд хээрийн бүсийн шинжийг илтгэнэ (Батчулуун, 2020). Бүс нутгийн сээр нуруутан амьтдын зүйлийн олон янз байдал болон амьдах орчны өнөөгийн төлөв байдлыг тодрууллаа. Тухайн судалгааны талбайн зүйлийн олон янз байдлыг гаргахдаа өмнөх судлаачдын судалгааны баримт, ном хэвлэлийн тойм болоод өөрсдийн хийсэн судалгаа, ажиглалтын үр дүнд тулгуурлав. Одоогоор төсөл хэрэгжих нутагт 47 зүйл шувуу, 26 зүйл хөхтөн, 5 зүйл 2 нутагтан, мөлхөгч тохиолдоно. Манай судалгааны баг 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр тус төслийн талбайд судалгаа хийсэн бөгөөд судалгааны дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 5 дугаар бүлгийн 87–92 дугаар хуудсанд хавсаргав.

Хөрсөн бүрхэвч: Хээрийн судалгаа: Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших “Хамтын эх булаг” ХХК-ний “Туулын зүүн дэнж” нэртэй алтны шороон орд орчмын хөрсний төлөв байдлыг тодруулж үнэлгээ өгөх зорилгоор хээрийн судалгаа хийсэн. Үүнд: Хөрсний гадаргын төлөв байдал, хөрсний үе давхаргын морфологи шинж чанар, хөрсөнд нөлөөлж буй хүчин зүйлс зэргийг тодруулж улмаар хөрсний хими, физик шинж чанарын төлөв байдлыг тодруулах зорилгоор нийт 2 цэгт хөрсний зүсэлт хийж т хөрсний дээж авсан.

Судалгаанд хамрагдсан дээжүүдийн хөрсний урвалын үзүүлэлт (pH) 8.8–9.3 байгаа нь хөрс хүчтэй шүлтлэг шинжтэйг илтгэж байна. Давсны агууламж 0.06–0.15% байгаа нь хөрс давсжилт багатай ангилалд хамаарахыг харуулна. Кальцийн карбонатын (CaCO_3) хэмжээ 0.0–3.1% хооронд хэлбэлзэж байгаа нь уг хөрсийг сул карбонаттай гэж үзэх үндэслэл болно.

Хөрсний ялзмагийн агууламж 1.9–3.42% байгаа нь дунд зэргийн хангалттай түвшинд байна. Шингээгдсэн суурийн найрлагад кальци, магни зонхилж, тэдгээрийн хэмжээ харьцангуй өндөр байгаа нь хөрсний суурийн ханалт сайн, физик шинж чанар тогтвортой байгааг илтгэнэ. Харин шим тэжээлийн элементүүдийн хувьд фосфор (P_2O_5) дунд түвшинд, кали (K_2O) бага–дунд түвшинд байна.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Химийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд Монгол улсын “MNS 5850:2019” стандарттай харьцуулахад хөрсний бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээ хэмжээнээсээ хэтрээгүй тул хөрсийг бохирдолгүй гэж үзэж байна.

Хөрсний элэгдэл, эвдрэл

Төслийн талбайд өмнөх жилүүдэд явагдсан хайгуул, олборлолтын үйл ажиллагааны улмаас хөрсний дээд үе хэсэгчлэн эвдэрсэн байдал ажиглагдаж байна. Ил уурхайн малталт, шороон овоолго, түр зам талбайн нөлөөгөөр байгалийн

хэв шинж алдагдаж, ургамлын бүрхэвч сийрэгжсэн, зарим хэсэгт бүрэн утсан байна.

Хөрсний эвдрэл нь ихэвчлэн ашиглалт явуулсан хэсэгт төвлөрсөн бөгөөд төслийн талбайн захын болон нөлөөлөл багатай бүсүүдэд байгалийн байдал харьцангуй хадгалагдсан байна. Эвдэрсэн хэсгүүдэд хөрсний бүтэц сийрэгжиж, салхи болон усны элэгдэлд өртөх эрсдэл өндөр байгаа боловч эвдрэлийн цар хүрээ нь нутгийн хэмжээнд өргөн тархаагүй байна.

Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр төслийн талбайд нийт 107.9 га газар эвдрэлд өртсөн байна. Үүнээс овоолго 87.5 га, эргэлтийн усан сан 10 га, уурхайн зам 10.35 га талбайг тус тус эзэлж байгаа бол баяжуулах үйлдвэр 0.004 га, барилга байгууламж 0.036 га, ажилчдын байр 0.02 га талбайг хамарч байна. Цаашид уурхайн ашиглалтын эцсийн жил гэхэд нийт 138.1 га эвдрэлд өртөхөөр байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Хамтын Эх Булаг” ХХК-ийн алтны шороон ордыг ашиглах явцад дараах сөрөг нөлөөлөл үзүүлэх юм.

Хүснэгт 10. Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Орчин	Сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Эрсдэлийн зэрэглэл
Газрын хэвлий	Алт олборлох, уурхайн барилга байгууламжаар эвдрэлд орно.	Төслийн талбайд	Их
Агаар	Олон хүний хөдөлгөөн, машин механизмын яндангаас гарах утаанаас болж агаар бохирдоно.	Төслийн талбай, түүний орчим	Дунд
Хөрсөн бүрхэвч	0.1 га талбайн хөрсөн бүрхэвч бүр мөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ургамлын бүрхэвч	0.1 га талбайн ургамал бүрмөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Тоосжилт, ХАБЭА-н дүрэм журмыг сайн хангаагүй тохиолдолд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	Төслийн талбайд	Бага
Ус	Газрын доорх усны түвшинд нөлөөлж улмаар нөөц багасах, хуурайших, голын усны түвшин багасах, шатахуун, шатах тослох материалын асгаралтаас ус бохирдож болзошгүй	Төслийн талбай орчим	Бага

3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ.
- Ажиллагсдын агаарын чанарын стандарт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглах дүрэм, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих, зааварчилгаа өгөх, сургалт явуулах
- Мөн уурхайн олборлолтын үед тоос дэгдэж, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.
- Уурхайн тээвэрлэлтийн шороон замд том оврын тээврийн хэрэгслийн нөлөөгөөр тоосжилт ихээр бий болж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хаягдлын аж ахуйд эргэлтийн усны систем ашиглан үйлдвэрлэлийн хаягдалтай хамт хаягдсан усыг цэвэрлэн үйлдвэрлэлд эргүүлэн хэрэглэх шаардлагатай бөгөөд орон нутгийн хөрсний шингээлт, ууршилтын тайлангүй учир бусад үйлдвэртэй харьцангуйгаар технологийн нийт хэрэгцээт усны 80%-ийг эргүүлж ашиглахаар тооцоолсон байна. Тоног төхөөрөмжүүдийн цэвэрлэгээ болон бусад хэрэгцээнд бүх технологийн усны 15-20%-ийг хэрэглэнэ.

- Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдож болзошгүй.
- Ахуйн хатуу, шингэн хог хаягдалдаа зөв менежмент явуулаагүйгээс болж гүний ус бактер болон химийн бохирдолд орж болзошгүй.
- Технологийн хэрэгцээндээ шаардлагатай усыг газрын доорх уснаас ашиглаж байгаа тул газрын доорх усны нөөц баялаг багасах
- Ахуйн бохир хаягдал гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Уурхайн техник хэрэгсэлд ашиглагдах шатах тослох материал алдагдсанаас болж хөрсөн бүрхэвч хүнд металаар бохирдож улмаар гүний усанд нэвчих

3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороонд дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй
- Уг төсөл хэрэгжсэнээр тухайн төслийн талбай түүний орчмын бэлчээрийн талбай хомсодно.
- Хөрс хуулалт болон шимт хөрсийг хадгалах явцад хөрсний үржил шим нь алдагдах
- Машин техник, хүний нөлөөллөөр төслийн талбай түүний орчмын ургамлын зүйл устгаж үгүй болж оронд нь хөл газрын ургамлын зүйл түрэн ургаж болзошгүй.

3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

